



БАНКНЫ САЛБАРЫН ТОЙМ

2026 оны эхний хагас жилийн тайлан

Шоконд бэлэн үү ?

Шоконд бэлэн үү ?

Банкны салбарын үзүүлэлт харьцангуй тогтвортой, өсөлттэй, нийт актив өмнөх оны мөн үетэй харьцуулахад 26 хувиар нэмэгдлээ. Иргэд цалин, тэтгэврийн зээл түлхүү авчээ. Эдийн засгийн салбаруудын сэргэлтэд банкны олгож буй зээл чухал нөлөөтэй байна. Тухайлбал, бизнесийн зээл тэр дундаа уул уурхай, боловсруулах, барилга болон худалдаа, үйлчилгээний салбарт олгосон зээлийн хэмжээ тасралтгүй нэмэгджээ. Малын гаралтай түүхий эд, түлшний үнийн өсөлтөөс шалтгаалан инфляцын түвшин сүүлийн 3 сарын хугацаанд тасралтгүй нэмэгдэж гурван сарын өмнөхөөс 2 дахин өссөн байна.

Эхний хагас жилд эдийн засгийн өсөлт 7.7 хувьтай гарлаа. Оны эхнээс уул уурхайн салбар, түүнийг дагаад тээвэр, агуулахын салбарын тогтвортой өсөлттэй байгаа нь эдийн засгийн өсөлтөд чухал нөлөөтэй байна. Удаан хугацааны дараа ХАА-н салбар сэргэж эхэлсэн нь эдийн засгийн өсөлтийг дэмжлээ. Барилга, боловсруулах салбар аажмаар сэргэж эхэлсэн нь эдийн засгийн өсөлтөд эергээр нөлөөллөө. Манай улсын валютын нөөц өнгөрсөн онтой харьцуулахад 47 хувиар өсөж түүхэн дээд хэмжээнд хүрчээ.

Төсвийн алдагдал цар тахлын үетэй тэнцэж эхэлжээ. Төсвийн урсгал болон хөрөнгийн зардлыг нэмэгдүүлсэн нь инфляцыг өдөөж, эдийн засгийн өсөлтийг хязгаарлах нөхцөлийг бүрдүүлж байна. Гадаад хүчин зүйлээс шалтгаалж МУ-ын эдийн засаг томоохон нийлүүлэлтийн **шоконд өртөхөөр** байхад төсвийн зардлыг огцом нэмэгдүүлэх үр нөлөөг инфляцаар дамжин иргэд үүрэх дүр зураг харагдаж байна. Иймд одоогийн өргөн барьсан төсөв нь эдийн засагт үзүүлэх **шоконд бэлэн үү.**




Иргэдэд олгох хэрэглээний зээл нэмэгджээ.

Малчдад олгосон хэрэглээний зээлийн хэмжээ өссөн нь иргэдийн хэрэглээний зээл нэмэгдэхэд чухал нөлөө үзүүллээ.

Цалин, тэтгэвэр болон картын зээл өсөлттэй байгаа бол хадгаламж барьцаалсан зээл буурчээ.

Онцлох өөрчлөлт,
энгийн тайлбар

Иргэдийн зээл олголт, жил бүрийн II улирал



Онолын тодорхойлолт

2026 оны II
улирлын гүйцэтгэл

Банкны шинээр олгосон зээл

Жич: Тухайн жилд банкны шинээр гаргасан зээлийн хэмжээгээр зээлийн үлдэгдэл нэмэгддэг.

Шинээр иргэдэд олгосон
зээлийн хэмжээ нэмэгдэв.

7.4%

2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛД БАНКНЫ САЛБАРЫН ОНЦЛОХ ӨӨРЧЛӨЛТ, ЦААШДЫН ХАНДЛАГА



Банкнуудын бизнесийг дэмжихэд чиглэсэн зээлийн өсөлт үргэлжилсээр байна.



Банкнуудын чанаргүй зээлийн хэмжээ бага байна.



Төгрөгийн хадгаламжийн өгөөж тогтвортой байсан нь төгрөгийн хадгаламж нэмэгдэхэд чухал нөлөө үзүүлээ.



Системийн нөлөө бүхий 5 банкны санхүүгийн үзүүлэлт харьцангуй сайн байна.



Банкны салбарын актив 27 хувиар өслөө.



Банкнууд эдийн засгийн салбаруудыг дэмжих хангалттай өөрийн хөрөнгөтэй байна.

БАНКНУУДЫН САНХҮҮГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТ

2026 оны эхний хагас жилийн гүйцэтгэл

Эдийн засгийн өсөлтийг дэмжихэд чиглэсэн банкны салбарын зээлийн өсөлт үргэлжилсээр байна.


Эдийн засгийн салбаруудын өсөлтийг дэмжихэд чиглэсэн бизнесийн зээл олголт нэмэгджээ. Иргэдийн хэрэглээний зээл өсөлттэй байна.

Банкны зээлийн багц

Жич: Зээлийн үлдэгдэл нь шинээр олгосон зээлээр нэмэгдэж, эргэн төлөлтөөр буурч байдаг.

+16%

Зээлийн үлдэгдэл өсөв.




Эдийн засгийн салбаруудыг дэмжихэд чиглэсэн бизнесийн зээл олголт өндөр байна.

Уул уурхайн гаралтайн түүхий эдийн дэлхийн зах зээл дээрх үнэ нэмэгдсэнтэй холбоотойгоор уул уурхайн салбарт олгох зээлийн хэмжээ нэмэгджээ.

Боловсруулах, барилга болон худалдаа, үйлчилгээний салбарыг дэмжсэн зээл олголт өндөр байна.

Тэрбум ₮

Бизнесийн зээл олголт, жил бүрийн II улирал



Банкны шинээр олгосон зээл

Жич: Тухайн жилд банкны шинээр гаргасан зээлийн хэмжээгээр зээлийн үлдэгдэл нэмэгддэг.

Бизнесүүдэд шинээр олгосон зээл

30%

нэмэгджээ.

Банкны зээлийн чанар

Жич: 90 хоногоос дээш хугацаагаар зээлээ төлөөгүй нөхцөлд чанаргүй зээлд шилждэг.

Салбарын хэмжээнд
чанаргүй зээлийн хэмжээ

5%


Эх сурвалж: Монголбанк
Үндэсний статистикийн хороо

Банкны салбарын чанаргүй зээлийн хэмжээ бага зэрэг нэмэгджээ.


Иргэдийн хэрэглээний 10 зээл тутмын 1 нь чанаргүй байна.

Эдийн засгийн салбарууд харьцангуй өсөлттэй байгаа нь бизнесийн зээлийн чанаргүйдэл буурахад нөлөөлж байна.

Иргэдийн чанаргүй зээлийн харьцаа, жил бүрийн II улирал



Бизнесийн чанаргүй зээлийн харьцаа, жил бүрийн II улирал




Иргэдийн хугацаатай хадгаламжид итгэх итгэл нэмэгджээ.

Төгрөгийн ханш, инфляц харьцангуй тогтвортой байсан нь иргэдийн төгрөгт итгэх итгэлийг нэмэгдүүлжээ. Валютын хугацаатай хадгаламжаас илүүтэйгээр валютын харилцах болон төгрөгийн харилцахад түлхүү эх үүсвэр байршиж байна.

Банкны эх үүсвэр, жил бүрийн II улирал

Их наяд ₮



Банкны эх үүсвэр

Жич: Энэ нь банкны татан төвлөрүүлсэн харилцах, хадгаламжийг хэлдэг.

Төгрөгийн хадгаламж

25%

нэмэгджээ.

Банкны жигнэсэн дундаж хүү

Жич: Банкуудын шинээр татсан эх үүсвэрийн хүү, олгосон зээлийн хүү нь цаг хугацаа, мөнгөн дүнгийн хувьд жинлэгдсэн дундаж хүүг хэлнэ.

Зээлийн хүү


18%

Эх сурвалж: Монголбанк

Хүү тогтвортой байна.

Гадаад, дотоод эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан бодлогын хүүг өсгөсөн хэдий ч хүүгийн түвшин харьцангуй тогтвортой байна.

Эдийн засаг тогтворжиж буй нь зээлийн хүү аажмаар буурах хүлээлтийг үүсгэлээ.



БАНКНУУДЫН САНХҮҮГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТ

2026 оны эхний хагас жилийн гүйцэтгэл

Банкны актив буюу хөрөнгө

Жич: Банкны нийт өр төлбөр дээр нэмэх нь эздийн өмчийг бүхэлд нь банкны хөрөнгө буюу актив гэнэ.

Системийн нөлөө бүхий банкнуудын актив


25%

ӨСӨВ.

Системийн банкнуудын нийт актив өмнөх оны мөн үеэс 16 их наяд төгрөгөөр нэмэгджээ.

Голомт банкны актив 33 хувиар, Хаан банкны актив 31 хувиар тус тус өслөө.


Банкнуудын актив, жил бүрийн II улирлаар харуулав.



Системийн банкнуудын нийт эх үүсвэр өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8.7 их наяд төгрөгөөр нэмэгджээ.

Хаан банкны эх үүсвэр 27 хувиар, Голомт банкны эх үүсвэр 25, Хас банкны эх үүсвэр 18 хувиар тус тус нэмэгджээ.

Банкнуудын эх үүсвэр, жил бүрийн II улирал



Банкны эх үүсвэр

Жич: Иргэд, байгууллага болон хөрөнгө оруулагчдаас татсан өр төлбөрийн хэмжээ.

Банкнуудын эх үүсвэр


22%

НЭМЭГДЭВ.

Банкнудын өөрийн хөрөнгийн хүрэлцээ буурч буй хэдий ч хангалттай хэмжээний зээл гаргах хөрөнгөтэй байна.

Эдийн засгийг дэмжих, гол салбаруудын сэргэлтийг хурдасгахад чиглэсэн зээлийн өсөлт нь банкнудын өөрийн хөрөнгийн хүрэлцээг буурахад нөлөөлжээ.

Банкнудын өөрийн хөрөнгийн хүрэлцээ, жил бүрийн II улирал



2024	2025	2026	2024	2025	2026	2024	2025	2026	2024	2025	2026	2024	2025	2026
Хаан			ХХБ			Голомт			Төрийн банк			Хас		

Өөрийн хөрөнгийн хүрэлцээ

Жич: Санхүүгийн болон үйл ажиллагааны эрсдэлээс гарах алдагдлыг хаахад хүрэлцэхүйц хэмжээний өөрийн хөрөнгөтэй эсэхийг тодорхойлсон үнэлгээг хэлдэг

Банкнудын өөрийн хөрөнгийн хүрэлцээний дундаж

16%

Хөрвөх чадварын харьцаа

Жич: Богино хугацаат төлбөрүүдийг цаг тухайд нь төлөх чадварыг хэмждэг харьцаа.

Системийн нөлөө бүхий банкнуудын хөрвөх чадварын харьцаа үзүүлэлтийн дундаж


40%

Эх сурвалж: Банкнуудын аудитлагдаагүй тайлан

Системийн нөлөө бүхий 5 банкны хөрвөх чадварын харьцаа үзүүлэлт хэт өндөр хэвээр байна.

Банкнуудын хөрвөх чадварын харьцаа үзүүлэлт нэмэгджээ.

Банкнуудын хөрвөх чадварын харьцаа, жил бүрийн II улирал



2024	2025	2026
Хаан		
2024	2025	2026
ХХБ		
2024	2025	2026
Голомт		
2024	2025	2026
Төрийн банк		
2024	2025	2026
Хас		


МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН

2026 оны эхний хагас жил: Эдийн засгийн өсөлт 7.7 хувьтай гарлаа. Уул уурхайн салбар, түүнийг дагаад тээвэр, агуулахын салбарын өсөлт харьцангуй хурдан байсан нь эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлжээ. Боловсруулах болон эрчим хүчний салбар сэргэж байна. ХАА-н салбарын сэргэлт нь эдийн засгийн өсөлтийг дэмжлээ. Эрэлтийн талаас нь харвал хэрэглээ болон хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдсэн нь эдийн засгийн сэргэлтийг нэмэгдүүлсэн бол импортын хэмжээ буурч буй нь өсөлтөд эерэг нөлөө үзүүлжээ. Нийлүүлэлтийн гаралтай инфляцын түвшин нэмэгдэж байна.

Төлөв байдал: Хэрэв цаашид түлш шатахууны хомсдол болон үнийн өсөлт үргэлжилбэл нийт салбарт сөргөөр нөлөөлж нийлүүлэлтийн гаралтай үнийн өсөлт буй болох цаашлаад эдийн засгийн өсөлтийг сааруулах эрсдэлтэй байна. Ялангуяа тээвэр, логистик, ХАА-н салбарын өсөлтөд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна.

2026 оны эхний хагас жилд эдийн засаг 7.7 хувиар өсөв.

Уул уурхайн салбарын өсөлт түүнийг дагасан тээвэр, агуулах болон үйлчилгээний салбар эрчимжиж эхэлсэн нь эдийн засгийн өсөлтийн дийлэнх хувийг бүрдүүлэв. Боловсруулах болон барилгын салбар сэргэж эхэлсэн нь эдийн засгийн өсөлтөд чухал нөлөө үзүүллээ. Цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалан ХАА-н салбар уналттай байгаа нь эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөллөө.




Гадаад худалдааны тэнцэл 4.3 тэрбум долларын ашигтай гарлаа.

Нүүрс болон төмрийн хүдрийн тоо хэмжээ өсөлттэй байхын зэрэгцээ малын гаралтай түүхий эдийн экспорт нэмэгджээ. Импортын бараа бүтээгдэхүүн тэр дундаа авто бензин, дизель түлшний хэрэглээ нэмэгдсэн нь импортын өсөлтийн дийлэнх хэсгийг бүрдүүлээ.

Уул уурхайн гол бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэмэгдсэн нь **экспортын өсөлтөд** нөлөөллөө.

Хувиар




Хэрэглээний болон нефтийн бүтээгдэхүүний **импорт нэмэгджээ.**

Хувиар



Экспортын өсөлт нь **худалдааны тэнцэл ашигтай** гарахад нөлөөллөө.


Тэрбум.доллар



Төлбөрийн тэнцэл 567 сая ам долларын ашигтай байна.

Урсгал дансны ашигтай гарахад уул уурхайн гаралтай бүтээгдэхүүний экспорт нэмэгдсэн нь нөлөөллөө. Нөгөө талаас импортын хэмжээ буурсан нь урсгал данс ашигтай гарахад эерэг нөлөө үзүүллээ.


Санхүүгийн данс алдагдалтай буюу манай улсад орж ирэх гадаадын хөрөнгө оруулалт багасаж байна.



Инфляцын түвшин оны эхний улирлаас хоёр дахин нэмэгдэв.

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, тэр дундаа махны үнийн өсөлтөөс үүдэлтэй махны үнэ өссөн нь хэрэглээний үнэ өсөхөд чухал нөлөө үзүүлээ. Ойрх дорнодод гарсан мөргөлдөөний улмаас газрын тосны үнэ нэмэгдсэн нь өргөн хэрэглээний үнийн өсөлтийг дэмжлээ. Инфляц аажмаар нэмэгдэж буй нь бодит хадгаламжийн өгөөжийг сөрөг болоход хүргэлээ.

Инфляцын түвшин аажмаар нэмэгдэж **төгрөгийн хадгаламжийн бодит өгөөж** буурахад нөлөөллөө.



Төсвийн тэнцэл 2.1 их наяд төгрөгийн алдагдалтай гарч төсвийн алдагдлын дарамт нэмэгдэж байна.


Уул уурхайн гаралтай бүтээгдэхүүний экспорт нэмэгдсэн нь төсвийн орлого нэмэгдэхэд чухал нөлөө үзүүлээ.

Урсгал болон хөрөнгийн зардлын өсөлт нь төсвийн зарлагын дийлэнх хувийг эзэлжээ.

Үндсэн тэнцэл ашигтай байгаа ч цаашид энэ байдлаар явахад алдагдалд хүрч төсвийн алдагдлын дарамт нэмэгдэх төлөвтэй байна.


Төсвийн татварын орлого өмнөх оны мөн үеэс 10 хувиар өсжээ.

ДНБ-д эзлэх хувиар




Нийт төсвийн зарлага 20 хувиар нэмэгджээ.

ДНБ-д эзлэх хувиар




Төсвийн үндсэн тэнцэл ашигтай байна.

ДНБ-д эзлэх хувиар




Өрхийн бодит орлого, зарлага өмнөх оны мөн үеэс 4.8 хувиар буурчээ. Бодит орлого нь бодит зарлагаас 174 мянган төгрөгөөр илүү байна.

Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээний орлого буурсан нь **бодит орлого** буурахад нөлөөлжээ.



Хүнсний бус бараа бүтээгдэхүүний **зарлага** буурсан нь бодит зардал буурахад нөлөөлжээ.



НИЙЛҮҮЛЭЛТИЙН ШОК БА ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ



ОХУ-ын 89 мужийн 58-д нь шатахууны хязгаарлалт хэрэгжиж байна.

Энгийн үед 5.3-5.6 сая баррелийг үйлдвэрлэдэг бол энэ оны 8 дугаар сарын байдлаар ОХУ нь өдөрт 3.6 баррель шатахуун үйлдвэрлэж байна. Энэ нь 2002 оноос хойших хамгийн доод үзүүлэлт юм.


Хязгаарлалтад орсон

Мэдээлэл олдоогүй.



Эх сурвалж: The Moscow Times. Datawrapper

Оны эхнээс аажмаар өссөөр 5 сар, 7 сард түлшний үнэ огцом нэмэгджээ.



Эх сурвалж: St. Petersburg International Mercantile Exchange (SPIMEX)

Oil giant Russia faces refinery bottleneck

Ukraine's intensifying attacks on Russian energy infrastructure are disrupting refinery operations, pushing one of the world's leading oil producers and exporters to import petroleum products



- Some refineries targeted in Russia

RUSSIA

Saint Petersburg

Yaroslavl 

Moscow ■

● Ryazan

- Voronezh

 **Saratov**

Orsk 

● **Volgograd**

Il'sky • Krasnodar

(Crime)
Annexed by
Russia in 2014

TÜRKİYE

Caspian

SWEDEN

FINLAND

Baltic
Sea

LATVIA

LITHUANIA

POLAND

BELARUS

Kyiv ■

UKRAINE

MOLDOVA

ROMANIA

500 km

- Russia is the world's **2nd-largest crude oil producer**

- The government extended the temporary ban on gasoline exports **until Jan. 31, 2027**

Gasoline production has fallen to a level sufficient to meet only 65% of domestic demand

● **Russia has imported more than 1 million barrels of gasoline by sea since late July**

July 2026
Daily average



3.7 million barrels

Refinery processing volumes **remained 28% below the 2025 average**


August 25, 2026 Source: S&P Global Commodities at Sea (CAS), Kpler



Ормузын хоолойгоор дамжих шатахууны импорт нь Төв Азийн улсуудад хамгийн том цохилтыг буй болгоод байна.

Ормузын хоолойгоор энгийн үед өдөрт 20.4-20.7 сая баррель газрын тос дамжин өнгөрдөг байсан бол мөргөлдөөний дараа 14.6 сая баррель болж 30 орчим хувиар буурав.

Япон, Өмнөд Солонгос, Энэтхэг, Малайз зэрэг улсуудын импорт буурч, нийлүүлэлт тасрав.



Ам доллар/баррель


	Сингапур биржийн дизелийн үнэ	Брент газрын тосны үнэ	Нефтийн бүтээгдэхүүний хилийн үнэ
Ойрх Дорнодын хурцадмал байдлын өмнөх үеийн дундаж (2025.M1-2026.M2)	87	69	101
Хурцадмал байдлын дараах үеийн дундаж	148	93	129
Үнийн өсөлт	70%	36%	28%

Ормузын хоолойгоор дамжих шатахууны импорт нь Төв Азийн улсуудад хамгийн том цохилтыг буй болгоод байна.

Ормузын хоолойгоор энгийн үед өдөрт 20.4-20.7 сая баррель газрын тос дамжин өнгөрдөг байсан бол мөргөлдөөний дараа 14.6 сая баррель болж 30 орчим хувиар буурав.

Япон, Өмнөд Солонгос, Энэтхэг, Малайз зэрэг улсуудын импорт буурч, нийлүүлэлт тасрав.

Disruptions to shipping and flights



Sources: IMF PortWatch; Flightradar. Note: Regional conflict may impair AIS reliability through GPS interference, signal spoofing, and intentional transponder shutdowns. PortWatch vessels include tankers, containers, dry bulk, roll-on/roll-off, and general cargo. Regional flights include routes to and from Bahrain, Iran, Israel, Jordan, Kuwait, Lebanon, Oman, Qatar, Saudi Arabia, Syria, and the UAE. Flights: 7-day moving average. Shipping: 30-day moving average.

Bab el-Mandeb transits fell by roughly half after the first major Houthi attack on commercial shipping in late 2023, and have stayed there since.


Strait of Hormuz transits held up through repeated regional flare-ups until a sharp drop in 2026, following renewed escalation.

Regional flights (Bahrain, Iran, Israel, Jordan, Kuwait, Lebanon, Oman, Qatar, Saudi Arabia, Syria, UAE) dropped off in tandem with the Hormuz decline.

Манай эхний 7 сарын байдлаар 1.7 сая тонн түлшийг 1.5 тэрбум доллароор худалдаж авчээ. Нефтийн бүтээгдэхүүний нийлүүлэлт сарын дундаж хэрэглээнээс доогуур түвшинд хүрч тасалдал үүслээ.


Сүүлийн 5 жилд нефтийн бүтээгдэхүүний хэрэглээ жилд дундаар 8.5 хувь нэмэгдэж байна.

Нефтийн бүтээгдэхүүний сарын дундаж хэрэглээ, мян.тонн



Оны эхний хагасын дараагаас нефтийн бүтээгдэхүүний нийлүүлэлт огцом буурч эхэлжээ.

Мян.тонн



Ийнхүү эдийн засгийн цаашдын төлөвт нөлөөлж болзошгүй эрсдэлүүд:

ДОТООД ЭДИЙН ЗАСАГ

Хүнсний үнэ нэмэгдэх:

- Хавар баруун аймгуудад гарсан малын гоц халдварт өвчинтэй холбоотойгоор махны нийлүүлэлт буурах
- Шатахууны хязгаарлалт, үнийн өсөлттэй холбоотойгоор мах, хүнсний ногооны нийлүүлэлт нэмэгдэхгүй, үнэ нэмэгдэх

Шатахуунтай холбоотой:

- Нийлүүлэлтийн хязгаарлалт үргэлжлэх
- Үнэ нэмэгдэх
- Шатахууны үнийн өсөлтийн дам нөлөө хүлээлтээс өндөр байх

Инфляцын хүлээлт нэмэгдэх:

Төсвийн дарамт нэмэгдэх:

- Төсвийн тодотголд зардал болон алдагдлыг 998 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэв.
- 2027 оны төсвийн төсөлд зардлыг 9.6 их наяд төгрөгөөр буюу 28 хувиар нэмэгдүүлж тусгажээ.

ГАДААД ЭДИЙН ЗАСАГ


Геополитикийн эрсдэл:

- Ойрх Дорнод дахь мөргөлдөөн үргэлжилж газрын тос болон түүхий эдийн үнэ өөрчлөгдөх.
- Украин – ОХУ-ын дайнаас шалтгаалан газрын тосны үнэ нэмэгдэх, нийлүүлэлт хязгаарлагдах.

Бусад гадаад эрсдэл:

- Хятад улсын манай талаас худалдаж авч буй нүүрсний тоо хэмжээ болон үнийн өсөлт цаашид үргэлжлэх
- Дэлхийн зах зээл дээр зэс болон алтны үнэ цаашид тогтмол нэмэгдэх


Шатахууны үнийн өсөлт нь мах, хүнсний ногоо, цаашлаад тээвэр логистикийн зардлаар дамжин инфляц нэмэгдэх үндсэн шалтгаан хэвээр байна.




Төсөөлөл	2026*	2027*
Суурь	10.2	6.3
Шатахууны хязгаарлалт	13.8	6.8
Шатахууны үнийн өсөлт	14.2	6.4
УУ-н экспорт нэмэгдэх	11	6.0
Дээрх нөхцөлүүд бүгд	18.6	7.0

Нийлүүлэлтийн гаралтай инфляц нэмэгдэж буй мөчид төсвийн зарлагыг нэмэгдүүлэх нь давхар эрэлтийн гаралтай инфляцыг нэмэгдүүлэх эрсдэлийг дагуулж байна.


Уул уурхайн бүтээгдэхүүний **үнэ сэргэхтэй** зэрэгцэн төсвийн орлогыг өндрөөр төсөвлөдөг хэвээр байна.



Цар тахлын үетэй харьцуулахад **3 дахин өндөр** төсвийн зардлыг төсөвлөжээ.



Disruptions to shipping and flights



Sources: IMF PortWatch; Flightradar. Note: Regional conflict may impair AIS reliability through GPS interference, signal spoofing, and intentional transponder shutdowns. PortWatch vessels include tankers, containers, dry bulk, roll-on/roll-off, and general cargo. Regional flights include routes to and from Bahrain, Iran, Israel, Jordan, Kuwait, Lebanon, Oman, Qatar, Saudi Arabia, Syria, and the UAE. Flights: 7-day moving average. Shipping: 30-day moving average.